



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2023/05/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Сайншанд сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 7052-3020 Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,

Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2023.02.24

№

1-6/119

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ж.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь байгууллагын албан хаагчид болон сумдын санхүүгийн ажилтнуудыг сургалтад хамруулж, тээвэр шатахууны зардалд 0.3 сая төгрөг, албан томилолтын зардалд 3.2 сая төгрөг, хоол, хүнсний зардалд 3.0 сая төгрөг, нийт 6.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах..." гэж заасныг зөрчсөн байна.

010000402

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага 10 тоотой ажиллахаар батлагдсан боловч тайлант оны сүүлийн саруудад орон тоог бүрэн нөхөж ажилласан. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 9.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Тайлант хугацаанд 7.1 сая төгрөгийн 3 гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэсэн байгаа боловч мөнгийг байгууллагын эд хариуцагчийн хувийн харилцах дансанд шилжүүлж, бэлнээр зарцуулсан байна. Бэлэн мөнгийг сургалтыг төлбөр, сургалтын үйл ажиллагаатай холбоотой зардалд зарцуулсан ба кассын ажиллагааны журамд бэлнээр зарцуулах зардлын ангилалд сургалтын зардал хамаарахгүй, зайлшгүй бэлнээр зарцуулах шаардлагатай үед үндэслэл бүхий албан бичиг, баримт үйлдэхээр заасан боловч энэ талаар баримт нотолгоо байхгүй байна. Мөн бэлэн мөнгөний гүйлгээг нягтлан бодох бүртгэлд мөнгөн кассын дансанд тусгаагүй байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,584,600.72</b>	<b>14,372,065.01</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>5,934,661.72</b>	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	189,000.00	-
335	<b>Бусад авлага</b>	<b>5,745,661.72</b>	-
3351	Байгууллагаас авах авлага	5,745,661.72	-
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>2,350,000.00</b>	-
3471	Урьдчилгаа тооцоо	2,350,000.00	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	2,350,000.00	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,299,939.00</b>	<b>14,372,065.01</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>10,299,939.00</b>	<b>14,372,065.01</b>
35410	Бичиг хэргийн материал	1,119,164.00	2,685,120.00
35420	Аж ахуйн материал	6,299,875.00	6,516,325.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,880,900.00	5,142,900.00
35440	Түлш, шатах тослох материал	-	27,720.01
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>48,070,539.46</b>	<b>35,326,712.20</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>48,070,539.46</b>	<b>35,326,712.20</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>47,063,122.66</b>	<b>34,751,045.32</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,900,000.00	39,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,955,000.00)	(25,935,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,497,599.00	32,797,399.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,441,769.41)	(20,310,636.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,952,366.00	17,632,266.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,890,072.93)	(9,332,983.35)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,007,416.80</b>	<b>575,666.88</b>
39301	Програм хангамж	2,016,000.00	2,016,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,008,583.20)	(1,440,333.12)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>66,655,140.18</b>	<b>49,698,777.21</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>66,655,140.18</b>	<b>49,698,777.21</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>66,655,140.18</b>	<b>49,698,777.21</b>
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>66,655,140.18</b>	<b>49,698,777.21</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	66,655,140.18	66,505,140.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,806,362.97)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>66,655,140.18</b>	<b>49,698,777.21</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>207,966,414.26</b>	<b>217,476,044.22</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,344,700.00</b>	
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>9,344,700.00</b>	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,344,700.00	4417144353 0056 0025707
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>198,621,714.26</b>	<b>217,476,044.22</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,350,000.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,800,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,550,000.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>191,271,714.26</b>	<b>217,476,044.22</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	191,271,714.26	217,476,044.22
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>202,287,111.46</b>	<b>234,282,407.19</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>202,287,111.46</b>	<b>234,282,407.19</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>200,620,711.46</b>	<b>232,608,107.19</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>141,626,489.44</b>	<b>154,712,464.65</b>
210101	Үндсэн цалин	131,997,489.44	117,282,365.26
210102	Нэмэгдэл	-	19,607,761.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,629,000.00	8,375,000.00
210104	Урамшуулал	-	9,447,338.36
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,384,810.56</b>	<b>18,715,895.52</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,269,210.56	12,909,653.59
210202	Тэтгэмжийн даатгал	1,278,900.00	1,518,782.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,023,100.00	1,208,305.94
210204	Ажилгүйдлийн даатгал	255,800.00	280,119.48
210205	Эрүүл мэндийн даатгал	2,557,800.00	2,799,034.08
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,406,613.52</b>	<b>7,127,764.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,381,356.52	2,110,700.77
210302	Түлш, халаалт	3,856,733.00	3,888,500.00
210303	Цэвэр, бохир ус	568,524.00	528,564.00
210304	Байрны түрээс	600,000.00	600,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,614,702.02</b>	<b>7,405,455.99</b>
210401	Бичиг хэрэг	1,078,236.00	1,190,244.00
210402	Тээвэр, шатахуун	4,460,200.00	5,180,679.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,076,266.02	1,034,532.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>85,034.00</b>	<b>461,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,034.00	-
210604	Урсгал засвар	83,000.00	461,600.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,581,000.00</b>	<b>14,792,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,581,000.00	14,792,300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,249.00	6,784,949.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,000.00	5,891,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	98,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	717,675.00	717,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,074.00	55,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,500.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,921,812.92	22,607,677.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,884,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,921,812.92	14,723,527.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,666,400.00	1,674,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,666,400.00	1,666,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,400.00	1,666,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		7,600.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		7,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,679,302.80	(16,806,362.97)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,679,302.80	(16,806,362.97)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>202,788,414.26</b>	<b>223,260,344.22</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>60,000.00</b>
120009	Бусад орлого		60,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>202,788,414.26</b>	<b>223,200,344.22</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,516,700.00	5,724,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,800,000.00	5,724,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,716,700.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	191,271,714.26	217,476,044.22
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	191,271,714.26	217,476,044.22
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>199,841,714.26</b>	<b>221,280,644.22</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>199,841,714.26</b>	<b>221,280,644.22</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>192,451,014.26</b>	<b>219,606,344.22</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	141,603,000.00	154,712,464.65
210101	Үндсэн цалин	131,974,000.00	117,282,365.26
210102	Нэмэгдэл	-	19,607,761.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,629,000.00	8,375,000.00
210104	Урамшуулал	-	9,447,388.36
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,408,300.00	18,715,895.52
210201	Тэтгэврийн даатгал	13,292,700.00	12,909,653.61
210202	Тэтгэмжийн даатгал	1,278,900.00	1,518,782.43

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,023,100.00	1,208,305.94
210204	Ажилгүйдлийн даатгал	255,800.00	280,119.48
210205	Эрүүл мэндийн даатгал	2,557,800.00	2,799,034.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,356,737.52</b>	<b>7,127,764.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,381,356.52	2,110,700.77
210302	Түлш, халаалт	3,856,733.00	3,888,500.00
210303	Цэвэр, бохир ус	518,648.00	528,564.00
210304	Байрны түрээс	600,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,435,527.74</b>	<b>8,769,270.28</b>
210401	Бичиг хэрэг	1,743,700.00	2,756,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,440,200.00	4,978,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,076,627.74	1,034,170.28
210404	Ном, хэвлэл	175,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,935,500.00</b>	<b>800,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	95,500.00	-
210604	Урсгал засвар	4,840,000.00	800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,500,000.00</b>	<b>14,792,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	14,792,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,045,249.00</b>	<b>6,784,949.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	5,891,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	98,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	717,675.00	717,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,074.00	55,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,500.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,166,700.00</b>	<b>7,903,700.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,166,700.00	7,903,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,390,700.00</b>	<b>1,674,300.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,666,400.00</b>	<b>1,666,700.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,400.00	1,666,700.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,724,300.00</b>	<b>7,600.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,724,300.00	7,600.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,946,700.00</b>	<b>1,979,700.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,946,700.00</b>	<b>1,979,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,946,700.00</b>	<b>1,979,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,946,700.00</b>	<b>1,979,700.00</b>
222001	Тоног төхөөрөмж	1,896,900.00	-
223001	Бусад хөрөнгө	1,049,800.00	1,979,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,946,700.00)</b>	<b>(1,979,700.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(0.00)</b>	<b>(0.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>-</b>

4417144353  
EFOA0056 9025707

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	62,525,837.38		62,525,837.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	00.00		00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>62,525,837.38</b>	-	<b>62,525,837.38</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	00.00		00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	00.00		00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	00.00		00.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	4,129,302.80		4,129,302.80
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>66,655,140.18</b>	-	<b>66,655,140.18</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(150,000.00)		(150,000.00)
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>66,505,140.18</b>	-	<b>66,505,140.18</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(16,806,362.97)		(16,806,362.97)
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>49,698,777.21</b>	-	<b>49,698,777.21</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>228,044,700.00</b>	<b>217,536,044.22</b>	<b>10,508,655.78</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>228,044,700.00</b>	<b>217,536,044.22</b>	<b>10,508,655.78</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>226,378,000.00</b>	<b>215,869,344.22</b>	<b>10,508,655.78</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>162,140,000.00</b>	<b>154,712,464.65</b>	<b>7,427,535.35</b>
210101	Үндсэн цалин	122,474,200.00	117,282,365.26	5,191,834.74
210102	Нэмэгдэл	20,865,300.00	19,607,761.03	1,257,538.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,820,000.00	8,375,000.00	445,000.00
210104	Урамшуулал	9,980,500.00	9,447,338.36	533,161.64

ЕН0А0056 9025707

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,267,500.00</b>	<b>18,715,895.52</b>	<b>1,551,604.48</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,861,900.00	12,909,653.61	952,246.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,621,400.00	1,518,782.43	102,617.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,217,100.00	1,208,305.94	8,794.06
210204	Ажилгүйдлийн даатгал	324,300.00	280,119.48	44,180.52
210205	Эрүүл мэндийн даатгал	3,242,800.00	2,799,034.06	443,765.94
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,924,700.00</b>	<b>7,127,764.77</b>	<b>796,935.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,242,500.00	2,110,700.77	(868,200.77)
210302	Түлш, халаалт	5,274,500.00	3,888,500.00	1,386,000.00
210303	Цэвэр, бохир ус	687,700.00	528,564.00	159,136.00
210304	Байрны түрээс	720,000.00	600,000.00	120,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,455,900.00</b>	<b>8,769,270.28</b>	<b>686,629.72</b>
210401	Бичиг хэрэг	2,756,200.00	2,756,200.00	-
210402	Тээвэр, шатахуун	5,440,200.00	4,978,900.00	461,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,259,500.00	1,034,170.28	225,329.72
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>800,000.00</b>	<b>800,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,792,300.00</b>	<b>14,792,300.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	14,792,300.00	14,792,300.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,830,900.00</b>	<b>6,784,949.00</b>	<b>45,951.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,891,700	5,891,700	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	125,000	98,000	27,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	736,200	717,675	18,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,600	55,574	26.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,400.00	22,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,166,700.00</b>	<b>4,166,700.00</b>	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,166,700.00	4,166,700.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,666,700.00</b>	<b>1,666,700.00</b>	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,666,700.00</b>	<b>1,666,700.00</b>	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	1,666,700.00	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>228,044,700.00</b>	<b>217,536,044.22</b>	<b>10,508,655.78</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>228,044,700.00</b>	<b>217,476,044.22</b>	<b>10,568,655.78</b>
132001	Орон нутгийн төсвөөс	228,044,700.00	217,476,044.22	10,568,655.78
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		<b>60,000.00</b>	<b>(60,000.00)</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		60,000.00	(60,000.00)
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>			

4417144353  
 ӨНӨӨДӨӨСӨН  
 2023.08.27

## Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа илрээгүй ба 13.9 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэн байна. Үүнээс, 6.8 сая төгрөгийн 3 зөрчилд 3 албан шаардлага, 7.1 сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв.

### 3.2 Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль үйлчилж эхэлснээс хойших албаны суудлын автомашиныг байгууллагын дарга хот дотор ажил, үйлчилгээнд ашиглаж, 0.4 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *“Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Байгууллагын албан хаагчид болон сумдын санхүүгийн ажилтнуудыг сургалтад хамруулж, тээвэр шатахууны зардалд 0.3 сая төгрөг, албан томилолтын зардалд 3.2 сая төгрөг, хоол, хүнсний зардалд 3.0 сая төгрөг, нийт 6.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна Үүнээс, 1.2 сая төгрөгийн зардал Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсан өдрөөс хойш хугацаанд гарсан/.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах...”* гэж заасныг зөрчсөн байна.

3. Бэлнээр мөнгөөр орлогын 7.1 сая төгрөг, зарлагын 7.1 сая төгрөг, нийт 14.2 сая төгрөгийн гүйлгээг тайлант онд гүйцэтгэсэн байна. Уг гүйлгээг байгууллагын кассын дансанд тусгахгүйгээр, бэлэн бус гүйлгээ мэтээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ”* гэж заасныг зөрчсөн байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд,

#### 1. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:* Тайлант оны эхний хагас жилээр эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах тушаал гарч, тооллогыг зохион байгуулсан тухай илтгэх хуудас байгаа боловч тооллогын бүртгэл хангалтгүй. Нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, тооллогын үр дүн буюу илүүдэл, дутагдал илэрсэн талаарх мэдээллийг баримтжуулаагүй байна. Мөн тооллогын бүртгэлийг батлагдсан маягт, загварын дагуу үйлдээгүй байна. Энэ нь хөрөнгийн илүүдэл болон дутагдлыг арилгах арга хэмжээг тухай бүр авахгүй байх, санхүүгийн тайлан дахь хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй... комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан зааврын гуравдугаар зүйлийн 7-д “Тооллогын дараа эд хариуцагч нарын тооцоог бодож илүүдлийг орлого болгох ба дутагдлыг төлүүлэх, эсвэл зарлага болгож шийдвэрлэнэ”, 8-д “Тооллогын комисс .. тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

- 1.2. Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон актыг холбогдох хууль, журмын дагуу үйлдэж, тооллогын үр дүнг баримтжуулах.

## **2. Бэлэн мөнгөний гүйлгээтэй холбоотой асуудал**

- 2.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд 7.1 сая төгрөгийн 3 гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэсэн байгаа боловч мөнгийг байгууллагын эд хариуцагчийн хувийн харилцах дансанд шилжүүлж, бэлнээр зарцуулсан байна. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт материал үйлдээгүй, зөвхөн бэлэн мөнгөний урьдчилгааны тайланг үйлджээ. Бэлэн мөнгийг сургалтыг төлбөр, сургалтын үйл ажиллагаатай холбоотой зардалд зарцуулсан ба кассын ажиллагааны журамд бэлнээр зарцуулах зардлын ангилалд сургалтын зардал хамаарахгүй, зайлшгүй бэлнээр зарцуулах шаардлагатай үед үндэслэл бүхий албан бичиг, баримт үйлдэхээр заасан боловч энэ талаар баримт нотолгоо байхгүй байна.

Кассын ажиллагааг журмын дагуу гүйцэтгэхгүй байх нь санхүүгийн зөрчил үүсэх үр дагавартай.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.2-т “Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картан дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно”, 2.3-т “Журмын 2.2-д зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн, шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно” гэж заасантай нийцэхгүй байна.

- 2.2. Өгсөн зөвлөмж: Мөнгөн кассын дээрх журмын 2.2-т заасан зардлыг зарцуулахаас бусад тохиолдолд бэлэн мөнгөөр гүйлгээг хийхгүй байх. Бэлэн мөнгөний гүйлгээг журамд заасны дагуу чек болон байгууллагын нэр дээрх төлбөр тооцооны дансанд шилжүүлэн гүйцэтгэх.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй	1	373.4			1	373.4	-	-	-	-	-	-
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	1	6,472.6			1	6,472.6			-	-		
Бэлэн мөнгөний гүйлгээг НББ-д кассын дансанд тусгаагүй	1				1							
Тооллогын бүртгэл, баримтыг журмын дагуу үйлдээгүй, үр дүнг тооцоогүй	1	-					1					
Бэлэн мөнгөний гүйлгээг кассын журам зөрчиж гүйцэтгэсэн	1	7,090.2					1	7,090.2				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>13,936.2</b>			<b>3</b>	<b>6,846.0</b>	<b>2</b>	<b>7,090.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		